


БАТЛАВ
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *ЖУ* Ж.УРАНЧИМЭГ



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ СПОРТЫН
VII НААДМЫН НЭГДСЭН ЗААВАР

2022 оны 02 дугаар сарын 10-ны өдөр
Говь-Алтай

АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ
2. НААДМЫН ХӨТӨЛБӨР
3. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА
4. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХУГАЦАА
5. ШАГНАЛ
6. СПОРТЫН ТӨРӨЛ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Биеийн тамир спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”-ын 2 дугаар заалтын 2.1 дэх хэсгийг үндэслэн Монголын үндэсний спортын наадмыг зохион байгуулахад энэхүү зааврыг баримтална.
- 1.2. Монголын үндэсний спортын VII их наадмын /цаашид наадам гэх/ зорилго нь үндэсний уламжлалт спортын төрлүүдийг хөгжүүлэх, хамгаалах, уламжлалт тоглоом наадгайн зан үйл, үндэсний ёс заншил, соёл, соёлын өвийг өсвөр залуу үеийнхэнд өвлүүлэх, сурталчилан таниулахад оршино.
- 1.3. Үндэсний спортын наадамд дараах зарчмыг баримтална.
 - Аймгийн хэмжээнд үндэсний спортоор хичээллэгсдийн бүх нийтийн оролцоог хангаж, иргэн бүр оролцох боломжийг бүрдүүлнэ.
 - Уламжлалт соёл, зан үйл, ил тод шүүлт, цэвэр шударга өрсөлдөөн, тамирчдын ёс зүйг эрхэмлэнэ.
 - Зан үйл, соёл, спортын бүтээгдэхүүнийг бий болгох, үндэсний соёлын биет бус өвийг хөгжүүлэх, өвлөн уламжлуулна.

ХОЁР: НААДМЫН ХӨТӨЛБӨР

- 2.1. Говь-Алтай аймгийн хэмжээнд олон нийтийн дунд түгээн дэлгэрүүлж, хөгжүүлэх боломжтой үндэсний спортын зуны 7, өвлийн 2 төрлөөр зохион байгуулна.

ГУРАВ: ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 3.1. Наадмын оролцогч нь 18 сум, 2 тосгоны албан байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтан албан хаагч, иргэд хөдөлмөрчид байна.
- 3.2. Наадамд оролцогчид 2022 оны 04 дүгээр сарын 10-ны дотор батлагдсан мэдүүлгийн дагуу баг, тамирчдаа бүртгэж govi-altai@sport.gov.mn хаягаар ирүүлсэн байна. /жич: Мэдүүлэг ирсэн баг тамирчдын мэдээлэл цахим бүртгэл орох тул үнэн зөв, алдаагүй бөглөн, компьютерт шивж гарган, баталгаажуулсан байна/
- 3.3. Баг тамирчид бэлтгэлийн болон үндэсний хувцасаар жигдэрсэн байна.
- 3.4. Наадамд оролцогч нь зуны спортын 2 төрлийг сонгон оролцоно.
- 3.5. Тамирчин өөрийн сонголтоор хичээллэж буй клуб, сум, албан байгууллага, аж ахуйн нэгж, хувиараа багаа бүрдүүлж оролцох сонголтоо хийж болно.
- 3.6. Наадамд оролцогчид эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байна.

ДӨРӨВ: ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХУГАЦАА

- 4.1. Анхан шатны тэмцээнийг албан байгууллага, аж ахуйн нэгж, сумдаа зохион байгуулж, мэдээг Биеийн тамир спортын газарт ирүүлнэ.
- 4.2. Наадмын өвлийн спортын төрлийг 2022 оны 02 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд Тайшир сумын Гэгээн нуурт, зуны спортын 6 төрлийг 2022 оны 05 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд, уран уургач, бугуйлч, эмнэг булгиулагчийн тэмцээнийг 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулна.
- 4.2. Наадамд оролцох баг, тамирчдын бэлтгэл сургуулилт, байр, хоол, унааны зардлыг тухайн сум, байгууллага хариуцна.

ТАВ: ШАГНАЛ

5.1. Наадмын төрөл тус бүрт эхний 3 байранд шалгарсан баг тамирчдыг медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулах бөгөөд 1-р байранд шалгарсан баг, тамирчдад шигшээ тэмцээнд оролцох эрх олгоно.

ЗУРГАА: ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ СПОРТЫН ТӨРӨЛ

№	Спортын төрөл	Оролцох тамирчдын тоо	Хугацаа	Нас
1	Мөсний шагайн харваа	Талын харваа: 1 хүн Цуваа харваа: 2 хүн Багийн харваа: 6 хүн	II/09	Насанд хүрэгчид /18-с дээш нас/
2	Мөсний сурын харваа	Цуваа харваа: 2 хүн Багийн харваа: 10 хүн	II/09	Насанд хүрэгчид /18-с дээш нас/
3	Үндэсний бөх	Улс, аймаг, сумын цолтой болон цолгүй 4 бөх	V/12	Насанд хүрэгчид /18-с дээш нас/
4	Үндэсний сурын харваа	Багийн харваа: 15 хүн Цуваа харваа: эрэгтэй-1, эмэгтэй-1 Зэв нүүлгэх: эрэгтэй-1, эмэгтэй-1	V/12-13	Насанд хүрэгчид /18-с дээш нас/
5	Урианхай сурын харваа	Багийн харваа: 12 хүн Цуваа харваа: эрэгтэй-1,	V/14	Насанд хүрэгчид /18-с дээш нас/
6	Уламжлалт сурын харваа	Багийн харваа: Эрэгтэй-5, эмэгтэй 3 нийт 8 хүн Цуваа харваа: эрэгтэй-1, эмэгтэй-1	V/15	Насанд хүрэгчид /18-с дээш нас/
7	Шагайн харваа	Багийн харваа: 8 хүн	V/14	Насанд хүрэгчид /18-с дээш нас/
8	Ширээний шагай	Ганцаарчилсан эрэгтэй-1, эмэгтэй-1, охид-1, хөвгүүд-1 / 16 хүртэлх насны/ Багийн тоглолт: 4 хүн	V/14	Насанд хүрэгчид /18-с дээш нас/
9	Уран уургач, бугуйлч, эмнэг булгиулагч	Уургач-1, бугуйлч-1, эмнэг булгиулагч-1	VIII/01	Насанд хүрэгчид /18-с дээш нас/

БАТЛАВ

2022 оны дугаар сарын-ны өдөр

**МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ СПОРТЫН VII ИХ НААДАМД
..... СУМААС /БАЙГУУЛЛАГААС/ ОРОЛЦОХ
БАГ ТАМИРЧДЫН МЭДҮҮЛЭГ**

Спортын төрөл

№	Зураг	Спортын зэрэг	Насны ангилал	Овог	Нэр	Хүйс	Регистрийн дугаар	Оршин суугаа хаяг	Төрсөн газар	Цахим хаяг	Утас	Ажил эрхлэлтийн байдал
	Зх4											

Жлч: Зургийн нягтралыг 300 пиксел байхаар сканардсан байна.

МЭДҮҮЛЭГ ГАРГАСАН

БАГИЙН АХЛАГЧ